



МОНГОЛ УЛСЫН
БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙДЫН
ТУШААЛ

2025 оны 02 сарын 20 өдөр

Дугаар А/48

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын батлан хамгаалах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1 дэх заалт, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2, 26 дугаар зүйлийн 26.3 дахь хэсэг, Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.13, 13.2.2, 13.2.5, 13.2.6 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, яамны Шинжлэх ухаан, технологи, инновацын зөвлөлийн 2025 оны анхдугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Батлан хамгаалахын сайдын нэрэмжит “Салбарын шинжлэх ухаан, технологи, инновацын шилдэг бүтээл шалгаруулах журам”-ыг хавсралтаар баталсугай.

2.Энэхүү журмыг батлагдсан өдрөөс эхлэн үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллахыг яамны Шинжлэх ухаан, технологи, инновацын зөвлөл (бригадын генерал Д.Ганхуяг), Зэвсэгт хүчний Жанжин штаб (хошууч генерал С.Ганбямба), Үндэсний батлан хамгаалахын их сургууль (бригадын генерал С.Дашзэвэг), Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэн (хурандаа Т.Мөнх-Оргил), Цэргийн төв эмнэлэг (хурандаа Б.Энх-Од), Батлан хамгаалахын төв архив (дэд хурандаа Ж.Гантулга), Монгол цэргийн музей (хурандаа Д.Ганзориг)-д тус тус үүрэг болгосугай.

3.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Батлан хамгаалахын сайдын 2022 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн “Журам батлах тухай” А/270 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (хурандаа Б.Эрхэмбаяр)-т даалгасугай.

САЙД



С.БЯМБАЦОГТ

1325100037

Батлан хамгаалахын сайдын 2025 оны
9-дугаар сарын 22-ны өдрийн
148 дугаар тушаалын хавсралт

**БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙДЫН НЭРЭМЖИТ
“ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИ, ИННОВАЦЫН
ШИЛДЭГ БҮТЭЭЛ” ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь батлан хамгаалах судлал, цэргийн шинжлэх ухаан, технологи, инновацыг хөгжүүлэх, чадавхыг бэхжүүлэхэд чиглэсэн судалгааны ажлын үр дүнгээр боловсруулан туурвисан нэг сэдэвт (монограф), хамтын бүтээл, орчин үеийн дэвшилтэд технологи, инновац, хиймэл оюун ухаанд суурилсан бүтээлийг сонгон шалгаруулж, тэдгээрийг цэргийн хэрэгт нэвтрүүлэх, сургалт, судалгааны эргэлтэд оруулахад дэмжлэг үзүүлэх, шагнаж урамшуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Батлан хамгаалахын сайдын нэрэмжит “Шинжлэх ухаан, технологи, инновацын шилдэг бүтээл”-ийг дараах чиглэл (төрөл)-ээр жил бүр сонгон шалгаруулна. Үүнд:

1.2.1.хэвлэмэл бүтээл:

- 1.2.1.1.аюулгүй байдал судлал;
- 1.2.1.2.батлан хамгаалах судлал;
- 1.2.1.3.цэргийн шинжлэх ухаан;
- 1.2.1.4.цэргийн түүх судлал.

1.2.2.цэргийн зэвсэглэл, техник, технологи, инновац, программ хангамжийн бүтээл:

- 1.2.2.1.цэргийн зэвсэглэл, техник;
- 1.2.2.2.цэргийн технологи, инновацын дэвшил;
- 1.2.2.3.шинэ бүтээл, оновчтой санал;
- 1.2.2.4.хиймэл оюун ухаан, программ хангамж;

1.2.3.залуу судлагч, зохион бүтээгчийн бүтээл.

1.3. Шалгарсан бүтээлийн төрөл тус бүрээр “Тэргүүн”, “Дэд”, “Гутгаар” байр шалгаруулах бөгөөд байр эзэлсэн бүтээл тус бүрд шилдэг бүтээлийн өргөмжлөл, мөнгөн шагнал олгоно.

Хоёр. Шалгаруулалтад нэр дэвшүүлэх бүтээлд тавигдах шаардлага

2.1. Шалгаруулалтад эрдэм шинжилгээ, судалгаа, туршилт, зохион бүтээх ажлын үр дүнд бий болсон, батлан хамгаалах эрх ашигт нийцсэн, Үндэсний аюулгүй байдлыг хангах, батлан хамгаалах, Зэвсэгт хүчний чадавхыг бэхжүүлэхэд чиглэсэн, цэргийн шинэчлэл, салбарын шинжлэх ухаан, технологи, инновацыг хөгжүүлэхэд дорвитой хувь нэмэр оруулах бүтээлийг нэр дэвшүүлнэ.

2.2. Шалгаруулалтад Батлан хамгаалах салбар, бусад эрдэм шинжилгээ, сургалтын байгууллага, аж ахуйн нэгж, эрдэмтэн, судлаачдын хамтлаг, хувь хүмүүс энэ журмын 1.2-т заасан чиглэл (төрөл)-д сүүлийн 3 жилийн дотор туурвисан (зохион бүтээсэн) бүтээлийг дэвшүүлж болох бөгөөд дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

2.2.1.Патентын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.11 дэх заалт, мөн хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэгт заасан шинэ бүтээл, ашигтай загварын патент, зохиогчийн эрхийн гэрчилгээ авсан (авахаар мэдүүлсэн) байх;

2.2.2.энэ журмын 1.2.2.4-т заасан төрөлд хамаарах бүтээл нь Патентын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2-т, мөн 9 дүгээр зүйлийн 9.2-т заасны дагуу шинэ бүтээл,

ашигтай загварт тооцогдох тул ашигтай загварын гэрчилгээ авсан, түүнийг авахаар мэдүүлсэн байх;

2.2.3.бүтээл нь аюулгүй байдал, батлан хамгаалах судлал, цэргийн шинжлэх ухаан, технологи, инновацыг хөгжүүлэхэд чиглэсэн, цэргийн хэрэгт нэвтрүүлэх, ашиглах, цаашид төсөл, хөтөлбөр болгон хэрэгжүүлэх, нийгэм, эдийн засгийн бодит тооцоо судалгаанд үндэслэгдсэн зэрэг өндөр ач холбогдолтой байх;

2.2.4.тухайн бүтээлийг хэвлэн нийтлүүлж, сургалт, судалгааны эргэлтэд оруулсан, зохион бүтээж, туршилт хийсэн, хэрэглээнд нэвтрүүлсэн зэрэг үр дүнтэй байх;

2.2.5.орчин үеийн дэвшилтэд технологи, инновацын шийдлийг агуулсан, хиймэл оюун ухаанд суурилсан байх;

2.2.6.цэргийн зэвсэглэл, техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах, дахин ашиглах боломжийг эрэлхийлсэн байх;

2.2.7.шинээр олдсон түүх, соёлын ховор нандин дурсгал, эд өлгийн зүйлс, ховор олдворын тухай эрдэм шинжилгээний ажлын үр дүнгээр хийсэн бүтээл, тайлан, даалгаварт судалгааны ажлын үр дүнгээр бий болсон, байгууллагын дотоод нөөцийг ашиглан зохион бүтээгдсэн шинэ, бүтээл, ашигтай загвар, гадаадын олон улсын уншилттай сэтгүүлд гадаад хэл дээр нийтлүүлсэн шилдэг эрдэм шинжилгээний өгүүлэл байж болно.

2.3. Хамтын бүтээлийг нэр дэвшүүлэхдээ зохиогчийн хамтлаг нь 3 хүнээс хэтрэхгүй байх;

2.4. Нэг сэдэвт болон хамтын бүтээлүүдийг үндэсний цахим сангийн хуулбарлалт шалгах программд шалгуулж, хуулбарлалтын түвшин 30 хувиас хэтрэхгүй байх;

2.5. Орчуулсан ном, сурах бичиг, гарын авлага, дахин хэвлэсэн материал болон өмнө нь нэр дэвшсэн бүтээлийг шалгаруулалтад хүлээн авахгүй.

Гурав. Шилдэг бүтээлийн шалгаруулалтын материалын бүрдүүлэлт

3.1. Батлан хамгаалахын сайдын нэрэмжит шилдэг бүтээлийн шалгаруулалтад нэр дэвшүүлэх бүтээлд энэ журмын 3.2-т заасны дагуу холбогдох материалыг бүрдүүлнэ.

3.2. Шилдэг бүтээлийн шалгаруулалтад ирүүлэх материалууд нь дараахаас бүрдэнэ. Үүнд:

3.2.1.шалгаруулалтад оролцуулах бүтээл (хэвлэмэл бүтээлийн эх хувь, зохион бүтээгдсэн бие анги, программ хангамж).

3.2.2.бүтээлийн товч танилцуулга (Үүнд: зохиогч /хамтран зохиогч/-ийн нэр, аюулгүй байдал, батлан хамгаалах судлал, цэргийн шинжлэх ухааны онол, аргагүй болон цэргийн зэвсэглэл, техник, технологи, инновацын шийдэлд оруулж буй хувь нэмэр, ач холбогдол, шинэлэг тал, үр ашиг, зарцуулсан зардлын тооцоо);

3.2.3.зохион бүтээгдсэн биет бүтээлд техникийн зураг, технологийн карт, нэг бүрийн болон олноор үйлдвэрлэхэд зарцуулах зардлын харьцуулсан судалгаа зэргийг хавсаргасан байна.

3.2.4.тухайн бүтээлийг шүүн хэлэлцээд Батлан хамгаалахын сайдын нэрэмжит оны шилдэг бүтээлийн шалгаруулалтад дэвшүүлж буй байгууллагын хурлын шийдвэр, тэмдэглэл;

3.2.5.тухайн бүтээлийг цэргийн хэрэгт, үйлдвэрлэлд туршиж, нэвтрүүлсэн (сургалт, судалгааны эргэлтэд оруулсан, цаашид үр дүнг ашиглах, хөгжүүлэх, шинэчлэн сайжруулах, төсөл, хөтөлбөр болгон хэрэгжүүлэх боломжтой эсэхийг баталгаажуулсан) тухай байгууллагын тодорхойлолт (шалгаруулалтад иргэн);

3.2.6.тухайн бүтээлд мэргэжлийн 2-оос доошгүй эрдэмтний өгсөн үнэлэлт, дүгнэлт, шүүмж;

3.2.7.шалгаруулалтад ирүүлж буй бүтээлийн оюуны өмчийн гэрчилгээ, патент, ашигтай загварын болон зохиогчийн эрхийн гэрчилгээ, тэдгээрийг авахаар мэдүүлсэн тухай маягтыг хавсаргана.

3.3. Нууцын зэрэгтэй бүтээлийг нэр дэвшүүлсэн тохиолдолд бүрдүүлсэн материалд нууцын тэмдэг дарсан байна.

3.4. Шилдэг бүтээлд нэр дэвшүүлэхээр ирүүлсэн бүтээлийг дараах тохиолдолд шалгаруулалтад оролцуулахгүй. Үүнд:

- 3.4.1.энэ журмын 2.2-т заасан тавигдах шаардлага хангаагүй;
- 3.4.2.холбогдох баримт бичгийг дутуу болон хуурамчаар бүрдүүлсэн;
- 3.4.3.энэ журмын 4.2-т заасан хугацаанд ирүүлээгүй.

3.5. Өмнө нь төр, засгийн болон үндэсний хэмжээний албан ёсны шагнал, шалгаруулалтад шалгарч байсан бүтээлийг хүлээн авч, давхардуулан шалгаруулахгүй.

3.6. Шалгаруулалтад зохиогч хэд хэдэн төрөлд бүтээл ирүүлж болно.

3.7. Шалгаруулалтад нэр дэвшүүлж байгаа хэвлэмэл бүтээлийг гурван хувь, программ хангамжийг CD, DVD хэлбэрээр хуулбарлан ирүүлнэ. Тухайн ирүүлсэн бүтээлийн нэг хувийг буцааж олгохгүй.

Дөрөв. Шилдэг бүтээлийг хүлээн авах, шалгаруулах

4.1. Батлан хамгаалахын сайдын нэрэмжит шилдэг бүтээлийн шалгаруулалтыг зохион байгуулах тухай зарыг тухайн жилийн 05 дугаар сард багтаан хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, цахим хуудсаар дамжуулан нээлттэйгээр нийтэд зарлана.

4.2. Шилдэг бүтээлийн шалгаруулалтад энэ журмын 2.2-т заасан байгууллага, хувь хүмүүсийн нэр дэвшүүлсэн бүтээлүүдийг энэ журмын 3.2-т заасан холбогдох материалын хамт тухайн жилийн 09 дүгээр сард багтаан яамны Шинжлэх ухаан, технологи, инновацын зөвлөлийн салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга нарт хүргүүлнэ.

4.3. Зэвсэгт хүчний анги, байгууллагуудаас ирүүлсэн бүтээлийг Зэвсэгт хүчний Жанжин штабын Шинжлэх ухаан, технологи, инновацын салбар зөвлөл энэ журмын 4.2-т заасан хугацаанд зохион байгуулж, шалгарсан бүтээл, холбогдох материалыг хүргүүлнэ.

4.4. Шалгаруулалтыг дараах 2 үе шаттайгаар зохион байгуулна. Үүнд:

4.4.1.эхний үе шатанд: шалгаруулалтыг энэ журмын 1.2.1-д заасан чиглэл (төрөл)-ээр шилдэг бүтээлийг "Цэргийн шинжлэх ухаан, аюулгүй байдал, батлан хамгаалах судлал"-ын салбар зөвлөл, мөн журмын 1.2.2, 1.2.3-т заасан чиглэл (төрөл)-ээр шилдэг бүтээлийг "Техник, технологи, инновац"-ын салбар зөвлөлүүд тус тус жил бүрийн 09 дүгээр сард багтаан шалгаруулна;

4.4.2.хоёрдугаар үе шатанд: энэ журмын 4.4.1-д заасан салбар зөвлөлүүдийн шалгаруулсан бүтээлүүдийг яамны Шинжлэх ухаан, технологи, инновацын зөвлөл жил бүрийн 10 дугаар сард багтаан эцсийн байдлаар хэлэлцэн, шийдвэрлэнэ.

4.5. Салбар зөвлөлүүдийг шалгаруулалтад ирүүлсэн бүтээлийг харгалзан 2 хүртэлх эрдэмтэн, мэргэжилтэн, албан тушаалтан оролцуулан өргөтгөж болно. -Тухайн эрдэмтэн, мэргэжилтнийг салбар зөвлөлүүд сонгож оролцуулна.

Бүтээл нь нэр дэвшсэн салбар зөвлөлийн дарга, үндсэн болон өргөтгөсөн гишүүн санал өгөх эрхгүйгээр оролцож болно.

4.6. Салбар зөвлөлүүдийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна. Шалгаруулалтыг явуулахдаа "Шинжлэх ухаан, технологийн тухай", "Патентын тухай", "Оюуны өмчийн тухай", "Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай" хуулиуд болон Засгийн газрын 2007 оны 147 дугаар тогтоолоор батлагдсан "Шинжлэх ухаан, технологийн шагнал олгох журам" болон Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны А/141 дүгээр тушаалаар батлагдсан "Эрдэм шинжилгээний шилдэг бүтээл шалгаруулж, урамшуулах журам"-д нийцүүлэн гаргасан энэхүү журмыг дагаж мөрдөнө.

4.7. Салбар зөвлөлүүдийн дарга, гишүүд ашиг сонирхлын зөрчлөөс ангид байна.

4.8. Салбар зөвлөлүүд шалгаруулалтыг дараах байдлаар зохион байгуулна. Үүнд:

4.8.1.салбар зөвлөлийн нарийн бичиг шалгаруулалтыг зохион байгуулахаас 3 хоногийн өмнө энэ журмын 1.2-т заасан чиглэл (төрөл)-д нэр дэвшүүлсэн бүтээл, холбогдох материалыг хүлээн авч шалгаруулах комиссын хуралдаанд танилцуулна. Салбар зөвлөлийн дарга, гишүүд бүтээл тус бүртэй нэг бүрчлэн танилцаад, энэ журмын 5 дахь хэсэгт заасан шалгуур, үзүүлэлтийн дагуу үнэлж, дүгнэнэ;

4.8.2.салбар зөвлөл нь чиглэл (төрөл) тус бүрээр шалгаруулсан шилдэг бүтээлүүдийг энэ журмын 3.2-т заасан холбогдох материал, шалгаруулсан тухай хурлын тэмдэглэл, шийдвэрийн хамт яамны Шинжлэх ухаан, технологи, инновацын зөвлөлийн Эрдэмтэн нарийн бичгийн даргад хүргүүлнэ;

4.8.3.шалгаруулалтыг зохион байгуулсан салбар зөвлөлийн дарга нар яамны Шинжлэх ухаан, технологи, инновацын зөвлөлийн хуралдаанд шилдэг бүтээлийг шалгаруулсан тухай дүнг танилцуулна. Зөвлөл шалгарсан бүтээл тус бүрийг нэг бүрчлэн хэлэлцэж, шийдвэр гаргана.

4.9. Зөвлөлийн гишүүний бүтээл нэр дэвшсэн тохиолдолд санал өгөх эрхгүй байна.

4.10. Зөвлөлийн гишүүд нь ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж шаардлагатай тохиолдолд санал өгөхөөс татгалзах эрхтэй.

4.11. Яамны Шинжлэх ухаан, технологи, инновацын зөвлөлийн хуралдааны шийдвэрийг Батлан хамгаалахын сайдад танилцуулж, дүнг сайдын тушаалаар баталгаажуулна.

Тав. Бүтээлийн шалгуур үзүүлэлт, үнэлгээ

5.1. "Хэвлэмэл" бүтээлийн төрөлд нэр дэвшсэн бүтээлийг үнэлэх хуудас

Шалгаруулалтын төрөл:

Бүтээлийн нэр:

Зохиогчийн нэр:

Огноо: /...../

№	Үзүүлэлт	Авах оноо
1.	Зохиогчийн эрх (авсан болон мэдүүлсэн):	15
2.	Шинжлэх ухаанд оруулж буй бодит хувь нэмэр, ач холбогдол:	15
3.	Хэвлэгдсэн байдал (стандарт, тоо, ширхэг):	10
4.	Бүтээлийн бичилт, зохион байгуулалт, агуулгын чанар:	15
5.	Сэдвийн судлагдсан байдал (үндэсний цахим сангийн хуулбарлалт шалгах программд шалгуулсан хувь хэмжээ):	10
6.	Бүтээлийн дүгнэлт (байгууллагын тодорхойлолт, хурлын тэмдэглэл, мэргэжлийн эрдэмтэн судлаачдаас өгсөн дүгнэлт, түүнд тусгагдсан санал, шүүмж):	10
7.	Бүтээлийг сургалт, судалгааны эргэлтэд оруулсан байдал (номын санд тавигдсан, сургалтад нэвтрүүлсэн):	10
8.	Үндэсний цахим сангийн хуулбарлалт шалгах программд шалгуулсан байдал (30 хувиас хэтрэхгүй байх):	15
Нийт оноо:		100

Үнэлгээ өгсөн:

Гарын үсэг:

5.2. "Цэргийн зэвсэглэл, техник, технологи, инновац, программ хангамж"-ийн бүтээлийн төрөлд нэр дэвшүүлсэн бүтээлийг үнэлэх хуудас

Шалгаруулалтын төрөл:

Бүтээлийн нэр:

Зохиогчийн нэр:
Огноо: /...../

№	Үзүүлэлт	Авах оноо
1.	Шинэ бүтээл, ашигтай загварын патент, зохиогчийн эрхийн гэрчилгээ (авсан болон мэдүүлсэн):	15
2.	Шинжлэх ухаанд оруулж буй бодит хувь нэмэр:	15
3.	Шинэ санаа, шийдэл (дэвшилтэт технологи, хиймэл оюун ухаанд суурилсан, симуляци загварчлал ашигласан):	15
4.	Бүтээлийн зохион бүтээц, үйлдвэрлэл (тоо, ширхэг, техникийн зураг, үр ашгийн тооцоо, зарцуулсан зардал):	10
5.	Бүтээлийн чанар байдал: (өнгө, үзэмж, ашигласан материал, загвар, хийц, аюулгүй байдал, бат бөх, удаан эдлэгдэх чадвар)	10
6.	Цэргийн хэрэгт нэвтрүүлэх боломж, практик хэрэглээ болгож, туршсан байдал, үр дүн:	10
7.	Бүтээлд өгсөн дүгнэлт: (байгууллагын тодорхойлолт, хурлын тэмдэглэл, мэргэжлийн эрдэмтэн судлаачдаас өгсөн дүгнэлт, түүнд тусгагдсан санал, шүүмж)	10
8.	Бүтээлийн эрэлт хэрэгцээ (цаашид төсөл, хөтөлбөр болгон хэрэгжүүлэх, нийгэм, эдийн засгийн бодит тооцоо судалгаанд үндэслэгдсэн):	15
Нийт оноо		100

5.2.1. "Хиймэл оюун ухаан, программ хангамж"-ийн бүтээл

№	Үзүүлэлт	Авах оноо
1.	Шинэ бүтээл, ашигтай загварын патент, зохиогчийн эрхийн гэрчилгээ (авсан болон мэдүүлсэн):	15
2.	Техникийн чанар байдал:	15
3.	Шинжлэх ухаанд оруулж буй хувь нэмэр, ач холбогдол:	15
4.	Шинэлэг байдал: (хиймэл оюун ухаан, дэвшилтэт технологи, шинэ аргачлалыг ашигласан байдал, одоо байгаа шийдлүүдээс ялгарах давуу тал)	10
5.	Цэргийн хэрэгт нэвтрүүлэх боломж, практик хэрэглээ болгож, туршсан байдал, үр дүн:	10
6.	Бүтээлд өгсөн дүгнэлт: (байгууллагын тодорхойлолт, хурлын тэмдэглэл, мэргэжлийн эрдэмтэн судлаачдаас өгсөн дүгнэлт, түүнд тусгагдсан санал, шүүмж)	10
7.	Эдийн засгийн үр ашиг: (хөгжүүлэлт, ашиглалтын зардал, орлого, ашгийн түвшин, хөрөнгө оруулалтын өгөөж)	10
8.	Бүтээлийн эрэлт хэрэгцээ (цаашид төсөл, хөтөлбөр болгон хэрэгжүүлэх, нийгэм, эдийн засгийн бодит тооцоо судалгаанд үндэслэгдсэн):	15
Нийт оноо		100

Үнэлгээ өгсөн:
Гарын үсэг:

5.3. "Залуу судлаач, зохион бүтээгч"-ийн төрөлд нэр дэвшсэн бүтээлийг үнэлэх хуудас

Шалгаруулалтын төрөл:
Бүтээлийн нэр:
Зохиогчийн нэр:
Огноо: /...../

№	Үзүүлэлт	Авах оноо
1.	Шинэ бүтээл, ашигтай загварын патент, зохиогчийн эрхийн гэрчилгээ (авсан болон мэдүүлсэн):	15
2.	Шинжлэх ухаанд оруулж буй бодит хувь нэмэр:	15
3.	Шинэ санаа, шийдэл (дэвшилтэт технологи, хиймэл оюун ухаанд суурилсан, симуляци загварчлал ашигласан):	15
4.	Бүтээлийн зохион бүтээц, үйлдвэрлэл (тоо, ширхэг, техникийн зураг, үр ашгийн тооцоо, зарцуулсан зардал):	10
5.	Бүтээлийн чанар байдал (өнгө, үзэмж, ашигласан материал, загвар, хийц, аюулгүй байдал, бат бөх, удаан эдлэгдэх чадвар):	10
6.	Цэргийн хэрэгт нэвтрүүлэх боломж, практик хэрэглээ болгож, туршсан байдал, үр дүн:	10
7.	Бүтээлд өгсөн дүгнэлт (байгууллагын тодорхойлолт, хурлын тэмдэглэл, мэргэжлийн эрдэмтэн судлаачдаас өгсөн дүгнэлт, түүнд тусгагдсан санал, шүүмж):	10
8.	Бүтээлийн эрэлт хэрэгцээ, цаашдын чиг хандлага:	15
Нийт оноо		100

Үнэлгээ өгсөн:

Гарын үсэг:

Зургаа. Шилдэг бүтээлийг шагнаж, урамшуулах

6.1. Батлан хамгаалахын сайдын нэрэмжит салбарын шинжлэх ухаан, технологи, инновацын шилдэг бүтээлийг олон нийтэд алдаршуулах арга хэмжээг жил бүрийн “Шинжлэх ухааны ажилтны өдөр”-өөр зохион байгуулна.

6.2. Тухайн жилд ирүүлсэн бүтээлээс хамааран шагнал нь мөнгөн урамшууллаас өөр хэлбэрээр байж болно. Шагналын асуудлыг яамны Шинжлэх ухаан, технологи, инновацын зөвлөл хэлэлцэн, Батлан хамгаалахын сайдад танилцуулж, шийдвэрлүүлнэ.

6.3. Шилдэг бүтээлийг шалгаруулах үйл ажиллагааны зардал болон шилдэг бүтээлд олгох өргөмжлөл, мөнгөн урамшууллын зардлыг батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний төсвийн багцад жил бүр тусгаж санхүүжүүлнэ.

Долоо. Бусад

7.1. Шалгарсан бүтээлүүдийг цэргийн хэрэгт нэвтрүүлэх, сургалт, судалгааны эргэлтэд оруулах, төсөл, хөтөлбөр болгон хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлыг яамны Шинжлэх ухаан, технологи, инновацын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэж, Батлан хамгаалахын сайдын зөвлөлийн хуралдаанд танилцуулан шийдвэрлүүлнэ.

7.2. Төрийн болон албаны нууцад хамаарах мэдээлэл бүхий бүтээл шалгарсан тохиолдолд уг бүтээлийн талаар нийтэд мэдээлэхгүй.

7.3. Шалгаруулалт, оюуны өмчтэй холбоотой маргаан үүсвэл хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлүүлнэ.

7.4. Тухайн шилдэг бүтээлд байгууллагаас давхар урамшуулал олгох асуудал энэхүү журамд хамаарахгүй болно.

БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМНЫ ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИ, ИННОВАЦЫН ЗӨВЛӨЛ